

АГУУЛГА

I.1 Төслийн нэр	3
I.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэлг	3
I.3 Газар зүйн байршил:	3
1.4 Ордын нөөц	4
1.5 Ашиглалтын систем	6
1.6 Уурхайн хүчин чадал	7
II. Төсөл хэрэгжиж буй бүс нутгийн байгаль орчин нийгэм эдийн засгийн тодорхойлолт	10
II.1 Байгаль орчны онцлог	10
II.2 Нийгэм эдийн засаг	11
III. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	12
III.1 Агаарын чанар	12
III.2 Хөрсөн бүрхэвч	12
III.3 Гадаргын болон газрын доорх ус	13
III.4 Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	14
III.5 Ургамлан нөмрөг	14
III.6 Амьтны аймаг	15
III.7 Нийгэм эдийн засаг	15
IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	16
V. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
VI. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
VII. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	18
VIII. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	18
IX. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
X. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
XI. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
XII. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20
XIII. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21
XIV. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №. 1. Төслийн талбай	3
Зураг №. 2. Ордын байрлал	4
Зураг №. 3 Хүдрийн биетийн нөөцийн блокийн 3D загвар, баруун, зүүн талаас харагдах байдал	5
Зураг №. 4 Ашиглалтын 5 дахь жилийн эцсийн байдал	7

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №. 1 Хүрмэн-1 ордын нөөцийн нэгдсэн хүснэгт	6
Хүснэгт №. 2 Ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд	7
Хүснэгт №. 3 Уурхайн календарчилсан төлөвлөгөө	8
Хүснэгт №. 4 Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа	9
Хүснэгт №. 5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	16

I. Төслийн товч танилцуулга

I.1 Төслийн нэр

MV-63000051 ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай “Хүрмэн-1” базальтын ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл.



Зураг №. 1. Төслийн талбай

I.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэлг

Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Евро базальт” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011842961
Регистрийн дугаар	6914357
Хаяг	Улаанбаатар, Сонгинохайрхан дүүргийн 18-р хороо, Үйлдвэрчний эвлэл, 53/2 тоот
Утас	96 016767

I.3 Газар зүйн байршил:


Тус компани нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилгоор Булган аймгийн Орхон сумын нутагт орших 2025 оны 11-р сарын 27-ны өдөр түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл хүссэн байдаг. 2023 оны 02-р сарын 03-ны өдрийн аймгийн засаг даргын дугаар А/68 тоот захирамжаар XV-63000051 дугаар бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн.

2023 онд өөрсдийн хөрөнгөөр тус талбайд хайгуулын ажил хийж, 2024 онд ЭБМЗ-өөр ордын нөөцийг батлуулж Булган аймгийн засаг даргын захирамжаар MV-63000051 дугаар бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон байна.

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 2. Ордын газарзүйн олбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	градус	Минут	секунд	Градус	минут	секунд
1	103	34	55.54	48	40	47.23
2	103	34	54.15	48	40	47.24
3	103	34	34.7	48	40	47.24
4	103	34	34.7	48	40	28
5	5	103	34	40.84	48	40
6	6	103	34	40.84	48	40
7	7	103	34	55.25	48	40
8	8	103	34	55.54	48	40



Зураг №. 2. Ордын байрлал


1.4 Ордын нөөц

2023 онд тус талбайн хэмжээнд хайгуулын ажил гүйцэтгэсэн. Тухайн хайгуулын ажлаар баганат өрөмдлөг, сорьцлолт, лабораторийн шинжилгээ, (суурин боловсруулалт), үр дүнгийн тайлан боловсруулалт гэх мэт ажлуудыг хийсэн. Энэ ордод БНМАУ-ын материал техникийн баазаас 1980-1981 онд эрдэс хөвөн үйлдвэрлэх зорилгоор Дархан, Эрдэнэтийн районд базальтын ордыг хайгуулын ажлыг явуулсан байна. Тус хайгуулаар Булган аймгийн Орхон, Эрдэнэтийн Хайртын овоо зэрэг ордуудыг илрүүлэн хайгуул судалгааны ажил эхэлсэн түүхтэй.

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Евро базальт ХХК нь чулуун хөвөнгийн үйлдвэр барьж байгаатай холбогдуулан түүхий эд бэлтгэх зорилгоор тус ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн базальтын ордыг нөөцийг бүрэн хэмжээнд судалж нөөцийг тогтоохоор 2023 онд “Евро базальт” ХХК нь хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

2023 онд хайгуулын ажлын үр дүнгээр зааврын дагуу галт уулын гарал үүсэлтэй базальтын ордыг ордын төрөлд хамааруулан хайгуулын шугам хоорондын зайг дунджаар 200 м, цооног хоорондын зайг дунджаар 100м-ээр сонгон, хайгуулын 4 шугамаар 20 цооногийг 14,4-33,5м гүнтэйгээр өрөмдөж сорьцлон, холбогдох лабораторид хүргүүлж шинжлүүлсэн.



Зураг №. 3 Хүдрийн биетийн нөөцийн блокийн 3D загвар, баруун, зүүн талаас харагдах байдал

Нөөцийн блок В-I: Нөөцийн В-I блокийн талбайд хайгуулын I-I' ба II-II' шугамуудын хооронд байрлах бөгөөд блокын хил нь цооног № СК-01, 02, 03, 04, 17, 18, 05, 06, 07, 08-аар цооногоор хязгаарлагдана. Блокын талбайн хөрс хуулалтын дундаж зузаан нь 0.68м байна. Блок дахь ашигт малтмалын зузаан нь дундажаар 19.5 м байна. Блокын талбай нь $70,816.28 \text{ м}^2$, базальтын ордыг нөөц нь $70,816.28 \times 19.5 \times 2,87 = 1,380,917.46 \text{ м}^3$ буюу 3,963,233.11 тн.

Нөөцийн блок В-II: Нөөцийн В-II блокийн талбайд хайгуулын II-II' ба III-III' шугамуудын хоорондох талбай хамаарах ба блокийн хил нь цооног № СК-18, 05, 06, 07, 08

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

19, 09, 10, 11, 12-оор цооногоор хязгаарлагдана. Хөрс хуулалтын дундаж зузаан нь 0.95 м байна. Блок дахь ашигт малтмалын зузаан нь дунджаар 13.41 м байна. Блокын талбай нь $83,940.61 \text{ м}^2$, базальтын ордыг нөөц нь $83,940.61 \times 13.41 = 1,125,643.58 \text{ м}^3$ буюу 3,230,597.07 тн .

Нөөцийн блок В-III: Нөөцийн В-III блокийн талбайд хайгуулын III-III' ба IV-IV' шугамуудын хоорондох талбай хамаарах ба блокийн хил нь цооног № СК-19, 09, 10, 11, 12, 20, 13, 14, 15, 16- аар цооногоор хязгаарлагдана. Хөрс хуулалтын дундаж зузаан нь 1.95 м байна. Блок дахь ашигт малтмалын зузаан нь дунджаар 9.76 м байна. Блокын талбай нь $84,213.81 \text{ м}^2$, базальтын ордыг нөөц нь $84,213.81 \times 9.76 = 821,926.78 \text{ м}^3$ буюу 2,358,929.87 тн .

Ордын базальтын ордыг нөөц бодитой В зэргээр 3,328,487.82 м^3 буюу 9,552,760.05 тн болно.

Хүснэгт №. 1 Хүрмэн-1 ордын нөөцийн нэгдсэн хүснэгт

Нөөцийн зэрэглэл, блокийн дугаар	Хөрс хуулалт	Ашигт давхаргын зузуун, м	Блокын талбай, м^2	Хөрс хуулалтын хэмжээ, м^3	Ашигт малтмалын нөөц, м^3	Ашигт малтмалын нөөц, тн
В-I	0.68	19.5	70,816.28	14,163.25	1,380,917.46	3,963,233.11
В-II	0.95	13.41	83,940.61	16,788.12	1,125,643.58	3,230,597.07
В-III	1.95	9.76	84,213.81	16,842.76	821,926.78	2,358,929.87
Бодитой /В/ нөөц					3,328,487.82	9,552,760.05
С-I	0.32	13.62	24,650.07	4,930.01	562,514.59	1,614,416.87
С-II	2.24	8.66	43,626.99	8,725.39	377,809.73	1,084,313.92
Боломжтой /С/ нөөц					940,324.32	2,698,730.79
Ордын нөөц В+С					4,268,812.14	12,251,490.84

Хүрмэн-1 талбайн базальтын ордыг нөөцийг бодитой /В/ 3,328,487.82 м^3 буюу 9,552,760.05 тн, боломжит /С/ зэргээр 940,324.32 м^3 буюу 2,698,730.79 тн-оор нийт нөөц 5,004,816.91 м^3 буюу 12,251,490.84 тн-оор тооцоолсон. Тус ордын бодитой нөөц /В/ нь жилд 50,000 тн базальт олборлох тохиолдолд Евро базальт компанийн (үйлдвэр) хэрэгцээг 61 жил бүрэн хангах юм.


1.5 Ашиглалтын систем

Хүрмэн-1 базальтын ордыг орд нь уул-техникийн ямар нэг хүндрэлгүй ба тээвэртэй, гадаад болон дотоод овоолготой ашиглалтын системээр уурхайн олборлолтыг явуулна.

Тээвэртэй, гадаад болон дотоод овоолготой ашиглалтын системд доголын өндөр, орлын өргөн, мөргөцөг дэх ажлын талбайн өргөн, догол дахь фронтын урт гэсэн үндсэн хэмжээснүүд байна.

Энэхүү ордыг тээвэртэй, гадаад болон дотоод овоолго бүхий ил уурхайн аргаар ашиглах ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээснүүдийг ашиглах экскаваторын техникийн үзүүлэлт болон ордын уул-геологийн нөхцөлийг үндэслэн тогтоосон.

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг №. 4 Ашиглалтын 5 дахь жилийн эцсийн байдал

Хүснэгт №. 2 Ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Ажлын доголын өндөр	м	5
2	Ажлын бус доголын өндөр	м	5
3	Аюулгүйн тавцан	м	3
4	Ажлын доголын өнцөг	град	70
5	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	град	60
6	Ил уурхайн хажуугийн налуугийн өнцөг	град	44
7	Экскаваторын орлын өргөн	м	10.6
8	Ажлын талбайн өргөн	м	28.8
9	Автозамын налуу	‰	100
10	Автозамын өргөн	м	12

1.6 Уурхайн хүчин чадал

Жилийн 50 мян.м³ хүчин чадалтайгаар 61 жил ашиглах бөгөөд 3,053.65 мян.м³ базальт олборлож 400.44 мян.м³ хөрс хуулалтын ажил хийхээр байна.

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**




График № 1. Уурхайн календарчилсан төлөвлөгөө

Хүснэгт №. 3 Уурхайн календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жил	Үйлдвэрлэлийн нөөц					
	Базальт		Хөрс хуулалт	Хөрс хуулалтын итгэлцүүр	Уулын цул	Овоолгод буух хөрс, Кс=1.2
	м³	тн	м³	м³/тн	м³	м³
1	50,000	143,500	10,598	0.07	60,598	12717.6
2	50,000	143,500	9,224	0.06	59,224	11068.8
3	50,000	143,500	7,092	0.05	57,092	8510.4
4	50,000	143,500	14,682	0.10	64,682	17618.4
5	50,000	143,500	7,783	0.05	57,783	9339.6
6-10	250,000	717,500	19,787	0.03	269,787	23744.4
11-20	500,000	1,435,000	103,615	0.07	603,615	124338.0
21-30	500,000	1,435,000	-	-	500,000	-
31-40	500,000	1,435,000	-	-	500,000	-
41-50	500,000	1,435,000	227,668	0.16	727,668	273201.6
51-61	553,653	1,588,984	-	-	553,653	-
НИЙТ	3,053,653	8,763,984	400,449	0.05	3,454,102	480,539

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.7 Уурхайн ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилд 153 хоног ажиллах бөгөөд тухайн ажиллах хугацаан дахь цаг агаарын нөхцөлөөс хамаарсан түр зогсолт зэрэг хоногуудыг тооцон уурхайг бодитоор 150 хоног ажиллана гэж төсөлд тусгалаа.

Хоногт нэг ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 9 цаг байна.

Хүснэгт №. 4 Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	Жилийн хуанлийн хоног	Хоног	365	-
2	Сул зогсолт		212	10 сараас 5 сар хүртэл
3	Цаг агаарын саатал	Хоног	3	-
4	Жилд ажиллах бодит хоног	Хоног	150	-
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	Ээлж	1	-
6	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	9	-
7	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.9	90.0%
8	Нэг ээлжин дэх цэвэр ажлын цаг	Цаг	8.1	Цаг ашиглалт тооцсон
9	Хоногт ажиллах бодит цаг	Цаг	8.1	Цаг ашиглалт тооцсон
10	Жилд ажиллах бодит цаг	Цаг	1215	Цаг ашиглалт тооцсон
11	Уурхайн цагийн хүчин чадал	м³/цаг	41.2	Цаг ашиглалт тооцсон
12	Уурхайн ээлжийн хүчин чадал	м³/ээлж	333	Хоногт 9 цагийн 1 ээлжээр ажиллана
13	Уурхайн хоногийн хүчин чадал	м³/хоног	333	
14	Уурхайн жилийн хүчин чадал	м³/жил	50000	Жилд бодитоор 150 хоног ажиллана

II. Төсөл хэрэгжиж буй бүс нутгийн байгаль орчин нийгэм эдийн засгийн тодорхойлолт

II.1 Байгаль орчны онцлог

Уул зүй: Орхон сум нь Монгол Улсын хойд төв хэсэгт, Булган аймгийн өмнөд хэсэгт, аймгийн төв Булган хотоос 25 км зайд Орхон голын эрэгт оршино. Хойд талаараа Булган аймгийн төв болон Бугат сумдтай, зүүнээрээ Орхон аймаг, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумтай, зүүн өмнөдөөрөө мөн аймгийн Бүрэгхангай сумтай, баруун өмнөдөөрөө мөн аймгийн Могод, Хишиг-Өндөр сумдтай, баруун талаараа мөн аймгийн Сайхан сумтай газраар тус тус хиллэдэг. Далайн түвшингээс дээш 1650-2098 метр өргөгдсөн Халиун, Мээж, Булган зэрэг өндөр уулстай.

Ус зүй: Тус сум нь гадаргын усан хангамжаар сайн, Орхон Сээр, Бийр, Шувуут, Могой, Залуу, Зүйл зэрэг голууд сумын нутгаар урсдаг. Ихэвчлэн гадаргын урсгал ус хэрэглэдэг. Орхон сумын төвийн дэргэдүүр урсан өнгөрдөг Орхон голын тухай товч сийрүүлбэл: Орхон гол нь Монголын хамгийн урт гол юм. Орхон гол нь Хангай нурууны Суварга хайрхан уулаас эх авч 1,124 км урсаад Сүхбаатар хотын дэргэд Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Энэ нь хамгийн том цутгал нь юм. Ус цуглуулах талбай нь 132,835 км² бөгөөд энэ нь Сэлэнгийн манай нутаг дахь ус цуглуулах талбайн 47% болдог байна. Орхон голын эх хэсгийг Хангай нурууны Байгалийн цогцолбор газарт багтаасан.

Уур амьсгал: Цэвдэг судлаач Бадрах /1971 он/-ын ангиллаар дундаж өндөрлөгийн баруун нь Монгол орны уур амьсгалын сэрүүн бүсэд хамрагдах бөгөөд хүйтэн өвөлтэй эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм. Орхон сумын цаг уурын ажиглах сууринд цаг агаарын сарын дундаж /температур/ дулааны үзүүлэлт өвлийн улирал 1-р сард 30°C-35°C, зуны улиралд 7-р сард +20°C+35°C хүрдэг ба салхины чиглэл гол төлөв баруун ба баруун хойноос зүүн урд зүг рүү салхилах ба зарим өвөл цас их хэмжээгээр унана. Жилд дунджаар 240мм хур тунадас унах бөгөөд 70% орчим нь дулааны улиралд унадаг.

Хөрс ба ургамал. Хөрсний бүтцийг үзвэл говь, хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Тэгш өндөрлөг, толгодорхог газарт бор саарал, саарал хөрс зонхилж, мяраалга борзон хайрга, чулуун хуягаар бүрхэгдсэн байдаг. Хонхор хотос тойром газруудаар хужир, мяраалга хөрс зонхилдог. Хөрсний бүтэц нь цаг агаарын байдалтай нягт холбоотой. Хур бороо элбэгтэй үед өвс ургамал их ургацтай, бага үед хатах, ус ширгэх, салхины үйл ажиллагаанаас болж хөрс хуурайших, элэгдэх, өгөршиж хөрсний бүтэц өөрчлөгдөж байна. Сумын нийт бэлчээрийн 4.5 хувь нь цэвэр бэлчээр, 59 хувь нь сөөгт бэлчээр, 22 хувь нь чулуурхаг бэлчээр, 14.5 хувь нь довонтой бэлчээр байна. Эмийн ургамлаас: Юлдэн тарваган шийр, өргөст сарнай, нохойн хошуу, говийн ганга, таван салаа, царван, хөх дэгд, шар дэгд, цөс өвс, арц, банздоо, бошго, сөд, соргол зэрэг олон зүйлийн эмийн ургамал ургадаг. Жимс: Жимсний төрлүүдээс Орхон ууланд мойл ургадаг.

Ан амьтан: Орхон сум нь амьтны аймгийн төрлөөр баян нутаг билээ. Агнуурын ан амьтан. Чоно, үнэг, хярс, бор туулай, дорго, хүрнэ, мануул, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан элэг тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага агнуурын ан амьтад эрс ховордсон байна.

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Жигүүртэн амьтдаас сар, элээ, хэрээ, харцага, тогоруу, ангир, шаазгай, шар шувуу, хэвлийгээр явагчдаас могой, гүрвэл, мэрэгч амьтдаас шар сүүлт, алаг даага, тарвага, зурам, махчин амьтдаас үнэг, чоно, хярс, мануул, шавж идэштнээс зараа элбэг тохиолддог. Усны шувууд: Тал хөндийгөөр Монгол Улсын улаан номд орсон нэн ховор Гангар хун, Хар тогоруу, Цэн тогоруу болон овогт тогоруунууд тааралдах ба Орхон гол, нуур тойрмын хөвөө орчимд галуу, нугас, ангир, хун овогт тогоруу зэрэг усны шувууд элбэг байна.

II.2 Нийгэм эдийн засаг

Эдийн засгийн гол харилцаа нь мал аж ахуй юм. Нутгийн ардууд таван хошуу мал малладаг. Хүн амын үндсэн хэсэг нь халх бөгөөд нүүдлийн байдлаар амьдардаг. Хамгийн их хүн амтай газар нь сумын төв юм. Аймгийн төв болон Эрдэнэт хоттой засмал замаар холбогдсон нь дэд бүтцийн хувьд чухал ач холбогдолтой юм. Суманд ХААН банк, Төрийн банк, Эмийн сан, дэлгүүр, зоогийн газар, дугуй засвар, ШТС-ууд ажилладаг.

- “Орхон мандал” компани-Гурил
- “Орхон сумын-Гэрийн цуулбар мод
- “Орхон эсгий” хоршооны- Эсгий, эсгий эдлэл
- Орхон сумын- Хангай үүлдрийн хонь
- Орхоны-Цагаан идээ зэрэг 5 төрлийн бүтээгдэхүүнийг сумын шилдэг брэнд бүтээгдэхүүнээр зарлаж сумын нэрийн хуудас болгон ажилладаг байна.

Бүтээн байгуулалт, тохижилтыг дээшлүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор суманд эсгий-эсгий эдлэл, модон эдлэл, гэрийн хээтэй цуулбар модны цех, сүү- сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхөрлөл амжилттай ажиллаж ард иргэдийн хэрэгцээг хангаж байна.

III. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

III.1 Агаарын чанар

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- Ажилчдын амрах байр сууцны гадна талбайг зүлэгжүүлж тохижуулж агаарын чанарыг сайжруулах
- Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм

III.2 Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Олон салаа зам гарган зорчих
- Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх

- Уурхайн гадаад болон дотоод тээврийн замыг хатуу хучилттай болгох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрд ачуулах, ангилан ялгаж байх
- Цэвэрлэх байгууламж болон ариун цэврийн байгууламжийг байгаль ээлтэй технологийг сонгон ашиглах эдгээрийн эвдрэл гэмтлийг шалгаж байх
- Уурхайн машин техник төхөөрөмжийн үзлэг шинжилгээг тогтмол хийж байх

III.3 Гадаргын болон газрын доорх ус

Тухайн район нь гидрогеологийн мужлалаар уулс хоорондын хотгор ихэвчлэн артезийн ус тархсан мужид багтана. /Н.А.Маринов 1963 он/. Судалгааны талбайд тархсан гүний, бялхмал, хувирмал чулуулагт ан цавын, цэрд-дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд нүх сүвийн ус тархжээ. Мөн гидравлик шинж чанараараа чөлөөт гадаргуутай, түрэлттэй ус тархсан байна.

Газрын доорх усны агуулагдсан чулуулгийн стратиграфийн ангилал, найрлага, газрын доорх усны хөдөлгөөн, тархалт байрлалын нөхцөлүүдээс нь хамааруулан дараах уст үе, давхаргуудыг ялгасан байна. Үүнд:

1. Дөрөвдөгчийн хурдсын уст үе
2. Доод цэрдийн Манлайн формацийн уст давхарга
3. Дээд юра-доод цэрдийн Могойт формацийн уст давхарга
4. Дунд девоны Баталхудгийн формацийн уст үе
5. Неопротерозойн карбонат ба хувирмал чулуулгийн уст давхарга
6. Палеозой-мезокайнозойн гүний чулуулгийн ан цавын ус

Дөрөвдөгчийн хурдсын уст үе: Дөрөвдөгчийн хурдсын уст үе хуурай сайруудын дагуу түүнчлэн жижиг нуурын хотгоруудад үүссэн пролюв, аллюв-пролюв, нуурын хурдсанд тархсан байна.

Ус агуулагч чулуулаг нь хайрга, Базальт, шавранцар, элсэнцэр болно. Хуурай сайрын дагуу тархсан пролювийн хурдсын зузаан нь 1-3 м, уст үеийн зузаан нь 2 м хүрдэг. Энд муу мөлгөржсөн хэмхдэст хурдас зонхилно.

Аллюв-пролюв, нуурын хурдсанд шаврын материалын хэмжээ өсч, хэмхдэсийн хэмжээ жижгэрч салаавчилсан үеүдийг үүсгэнэ. Зузаан нь 10-30 м. Уг уст үеийн усжилт харилцан адилгүй шаварлаг материалын агуулгаас ихээхэн хамаардаг. Ерөнхийдөө сул усжилттай. Хурдсуудын ундарга нь 0.5 л/с хүрдэг. Аллюв-пролюв, нуурын хурдсанд тархсан ус нь газрын доорх усны хөдөлгөөний тогтонги нөхцөлд оршдогоос сул давстай байдаг байна. Пролувийн хурдсын ус нь химийн найрлагын хувьд сайн, эрдэсжилт бага байна. Энэ нь тэжээгдлийн сайн нөхцөлд оршдогоор тайлбарлагдана.

Уг хурдсанд олон тооны гар худаг байрладаг. Агаарын хур тунадас ихтэй жилд эдгээр худгуудыг ашигладаг. Бага байх тохиолдолд гар худгууд хуурайшдаг байна. Үүнээс үзэхэд уг уст давхаргын гол тэжээгч нь агаарын хур тунадас юм.

Дөрөвдөгчийн уст үе газрын гадаргууд ойр оршдог тул /0.5-3.0 м/ усаа ууршилтаар ихээр алдаж, бага хэмжээгээр гипсометрийн хувьд дор байрлах бусад уст үе, давхаргуудад алддаг байна. Ууршилтанд ихээр өртөх нь усны химийн найрлагад

эрдэсжилт ихсэхэд нөлөөлдөг. Уг уст үе давхаргын усны химийн найрлага нь сульфатлаг, сульфат-хлорлог, хлорлог кальци-натрийн, натрийн найрлагатай.

Эрдэсжилт нь 0.8-1.5 г/л, хааяа 2 г/л түүнээс дээш байдаг. Нутгийн ардууд уг уст давхаргын усыг унд болон ахуйн хэрэгцээнд хэрэглэдэг.

III.4 Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Ажиллагсдын ихэнх нь дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй нөхцөлд ажиллахаар байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөх магадлалтай юм. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх магадлалтай байна. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

III.5 Ургамлан нөмрөг

Хүнд машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Амрах байрнаас хоолны газар хүрэх зам гэх мэт явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх
- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын зэрэг барилга байгууламжид галын аюулгүй ажиллагааны буланг хийх ажилчдад хэрэглэх заавар зөвлөгөө санамжийг тогтмол өгөх, сургалт зохион байгуулах

III.6 Амьтны аймаг

Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих газар тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл зэргээс жижиг амьтад дайжих, амьдрах орчин хумигдсан. Харин ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлж болох юм.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Хөрсийг зүй зохистой ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, тогтсон нэг замаар тээврийн хэрэгслүүдийг зорчуулах.
- Ховор амьтадыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехникийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгуулахын зөвлөмж авч хэрэгжүүлэх
- Уулын малталт, овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах
- Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах

III.7 Нийгэм эдийн засаг

Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална.

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

“Евро базальт” ХХК -ийн Булган аймгийн Орхон сумын нутагт орших “Хүрмэн-1” базальтын ордын 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө баримтлан боловсруулсан.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2025 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 10.4 сая/төг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт №. 5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Хэрэгжүүлсэн арга хэмжээ	БОМТ-ийн нийт зардал /сая.төг/,
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10.0
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5.0
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	-
Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	5.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2.4
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт	27.4

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

V. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны турш	-	-	-	3.0	Үйл ажиллагааны турш	
	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх	Үйл ажиллагааны турш	-	-	-	ҮА-ны зардалд	Үйл ажиллагааны турш	
	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хошуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах	Үйл ажиллагааны турш	-	-	-	3.0		
Хөрсөн бүрхэвч	Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	-	-	-	3.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Автомашин хурдыг	Үйл	-	-	-		Үйл	

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	ажиллагааны турш					ажиллагааны турш	
	Шаардлагагүй газар ухаж сэндийчихгүй байх.	Үйл ажиллагааны турш		-	-		Үйл ажиллагааны турш	
	Төслийн талбайд ангилан ялгах тасалгаатай хогийн сав байрлуулж сард 1 удаа төвлөрсөн цэгт хаях	Үйл ажиллагааны турш		-	-	1.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
Нийт			10.0 сая/төг					

VI. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2025 онд ордын уул техгикийн нөхцөлөөс хамаарч нөхөн сэргээлт хийх боломжгүй байгаа учир нөхөн сэргээлтийн ажил хийгдэх боломжгүй.

VII. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

2025 оны 11, 12 дугаар сард уурхайн бэлтгэл ажил хийгдэх тул хийгдэх боломжгүй.

VIII. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

IX. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Төслийн талбайд болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах.	Уурхайн кемп	-	-	2.5	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл байрлуулах.	Уурхайн кемп	-	-	2.5	Үйл ажиллагааны турш	
	Нийт			5.0 сая/төг			

X. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
Ахуйн болон хатуу хог хаягдал	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	Уурхайн кемп	-	-	-	5.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
Нийт			5.0 сая/ төг					

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

XI. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, сая/төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрсний шинжилгээ						
Хөрсний химийн үзүүлэлт (рН, Давс, ЦДЧ, CO ₂ , Ялзмаг, Са+Mg, Са, Mg P ₂ O ₅ , K ₂ O)	Төслийн талбай	Жилд 1 удаа	-	0.6	Ланд овнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Cu, Zn)	Төслийн талбай	Жилд 1 удаа	-	0.6	Ланд овнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	
Хөрсний эрүүл ахуй (нянгийн тоо, гэдэсний савханцрын титр, анаэробын)	Төслийн талбай	Жилд 1 удаа	-	0.6	Ланд овнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	
Усны чанар						
Усны химийн ерөнхий шинжилгээ (Cl, SO ₄ , NO ₂ , SO ₃ , CO ₃ , NO ₃ , HCO ₃) ерөнхий хатуулгын хэмжээ, исэлдэх чанар, физик шинж	Унд ахуйн усны эх үүсвэрээс	Жилд 1 удаа	-	0.6	ШУА, Газарзүй- Геозкологийн хүрээлэн, усны шинжилгээний лаборатори	MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх- дээж авах, хадгалах, зөөвөрлөх

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

чанар						
Орчны хяналт шинжилгээний нийт зардал		2.4 сая/төг				

XII. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /сая. Төг/	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он					
			I-улирал	II-улирал	III-улирал	IV-улирал		
1	Мэдээллийн самбар байрлуулах	2.5	-	-	-	+	Байгаль орчны мэргэжилтэн	
2	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгч ажиллах	2.5	-	-	-	+	Байгаль орчны мэргэжилтэн	
3	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах	Үйл ажиллагааны зардлаар	-	-	-	+	Байгаль орчны мэргэжилтэн	
4	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах.	Үйл ажиллагааны зардлаар	-	-	-	+	Уурхайн дарга	
Нийт						5.0		

**БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮРМЭН - 1” БАЗАЛТЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

XIV. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

БОМТ түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэрүүд	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах	Зохион байгуулах газар
Бомт-ийн биелэлтийг оршин суугчдад тайлагнах					
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Булган аймгийн Орхон сумын засаг захиргааны байгууллагад танилцуулж,хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	Сумын засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмжийг хүлээн авч шийдвэрлэх	Булган аймгийн Орхон сумын Засаг захиргааны байранд